

Эрхэм хүлээн авагч байгууллага болон дадлагажигчдын анхааралд

Дадлагажигч нь эрүүл мэндийн байгууллагад үзүүлэх тохиолдолд дадлагажигчийн өөрөө эзэмшдэг “ХАИДА/AOTS/-н дадлагажигчийн эмнэлгийн тусламж үйлчилгээний үнэмлэх” (цаашдаа “үзлэг эмчилгээний карт” гэх) болон “Дадлагажигчийн хувийн үзлэг эмчилгээний төлбөрийн нэхэмжлэх”, мөн “AOTS-н дадлагажигчийн үзлэг эмчилгээний үеийн хүсэлт” (үзлэг эмчилгээний картаа хавсаргах)-ээ авч ирэн, дараах байдлаар үзлэгт хамрагдана уу. (эмнэлгээс гадуур эм худалдан авах тохиолдолд тухайн эмийн санд ч энэ журам мөн адил үйлчилнэ) Мөн эмнэлэгт үзүүлэхдээ хүлээн авагч байгууллагын ажилтантай хамт ирэхийг хүсье.

Эмнэлгийн хүлээн авах дээр

“AOTS-н дадлагажигчийн эмнэлгийн тусламж үйлчилгээний үнэмлэх” (үзлэг эмчилгээний карт) болон “AOTS-н дадлагажигчийн үзлэг эмчилгээний үеийн хүсэлт”-ээ хүлээн авахад өгнө үү.

Анхаар) Дадлагын хугацаанд илэрсэн өвчин, гэнэтийн ослоос шалтгаалах гэмтэл бэртэлд шаардагдах эмчилгээний төлбөр бөгөөд анхны үзлэгээс, эсвэл гэмтсэн өдрөөс эхэлж тооцон 180 өдөр доторх эмнэлгийн тусламж үйлчилгээний төлбөр нь үүний объект болдог.

“Дадлагажигчийн хувийн үзлэг эмчилгээний төлбөрийн нэхэмжлэх”-д дадлагажигчийн овог нэр, өвчний шинж тэмдэг, хамт ирсэн хүний овог нэр зэрэг шаардлагатай мэдээллийг бөглөөд хүлээн авахад өгнө үү.

← “Үзлэг эмчилгээний карт”-нд холбогдох мэдээллийг бөглөнө үү.

← Шинж тэмдэг, шинж тэмдэг илэрсэн өдөр, цаг хугацаа зэрэг шаардлагатай мэдээллийг бөглөнө үү.
Гуравдагч этгээд нь, дагаж ирсэн хүн үү, дадлагажигчийн ахуй амьдралын зааварлагч уу? гэдгийг мөн бичнэ.

Үзлэг эмчилгээний төлбөрийг хэрхэн төлөх вэ

- 1) Эрүүл мэндийн байгууллагад үзлэг эмчилгээний төлбөрөө дадлагажигч өөрөө шүүд төлөхгүй тохиолдолд Эрүүл мэндийн байгууллагатай тусгайлан тохиролцсоны дагуу үзлэг эмчилгээний төлбөрийг хүлээн авах дээр өвчтөнд шүүд нэхэмжлэлгүйгээр, AOTS руу “Дадлагажигчийн хувийн үзлэг эмчилгээний төлбөрийн нэхэмжлэх”-ийг илгээх ба дараа нь даатгалын компаниас эмнэлэг рүү төлбөрийг хийж болно. (Үндэсний эрүүл мэндийн даатгалд хамрагдсан тохиолдолд өөрийн хариуцах төлбөрийн хэмжээгээр нь, хэрвээ даатгалд хамрагдаагүй бол нийт дүнгээр нь нэхэмжилнэ үү) Тиймээс үндсэндээ эмнэлгийн хүлээн авах дээр ямар ч төлбөр хийгдэхгүй гэсэн үг.
- 2) Дадлагажигч болон хүлээн авагч байгууллага нь эмнэлэгт үзлэг эмчилгээний төлбөрийг шүүд төлөх тохиолдолд Хүлээн авах дээр төлбөрөө төлөхийг шаардах тохиолдол байж болно. Тэр үед заавал төлж барагдуулах ёстой. (Үндэсний эрүүл мэндийн даатгалд хамрагдсан бол өөрийн хариуцах төлбөрийн хэмжээгээр, хэрвээ даатгалд хамрагдаагүй бол нийт дүнгээр нь төлнө үү)
Тэр тохиолдолд, “Дадлагажигчийн хувийн үзлэг эмчилгээний төлбөрийн нэхэмжлэх”-ийг хүлээн авагч байгууллагаас AOTS руу илгээн, улмаар даатгалын компаниас хүлээн авагч байгууллага руу төлбөрийг шилжүүлнэ.
<Үзлэг эмчилгээний төлбөрийг нэхэмжлэх арга>
 - (1) Тус нэхэмжлэхийн хамт ирсэн хүний мэдээллийн хоосон зайд анхны үзлэгийн огноо, өвчний юмуу гэмтлийн нэрийг заавал бичнэ (гэмтэж бэртсэн бол гэмтсэн огноог бичнэ)
 - (2) Тус нэхэмжлэхийн үзлэг эмчилгээний төлбөр нэхэмжлэх хүний мэдээллийн хэсэгт хүлээн авагч байгууллагын нэрийг, мөнгө шилжүүлэх албан байгууллагын хэсэгт хүлээн авгагч байгууллагын эзэмшдэг банкны дансыг бичнэ.
 - (3) Тус нэхэмжлэхтэй цуг төлбөрийн баримт (эх хувиар нь)-ыг хавсаргаж AOTS руу илгээнэ.
 - (4) Дараа сарын эцсээр даатгалын компаниас заасан данс руу нь мөнгийг шилжүүлнэ.

Эмийн санд эм худалдан авах тохиолдолд

Рецепт /жор/-ээр эм худалдан авахдаа ч дээр тайлбарласны дагуу “Дадлагажигчийн хувийн үзлэг эмчилгээний төлбөрийн нэхэмжлэх”, “Үзлэг эмчилгээний карт”, “AOTS-н дадлагажигчийн үзлэг эмчилгээний үеийн хүсэлт”-ээ эмийн санд өгнө. Төлбөр хийх аргачлал нь мөн адил. Гагцхүү хүлээн авагч байгууллага нь эмийн санд эмийн үнийг төлөх тохиолдолд “Дадлагажигчийн хувийн үзлэг эмчилгээний төлбөрийн нэхэмжлэх” дээрх хамт ирсэн хүний мэдээллийн хоосон зайд анхны үзлэгийн огноо, өвчний юмуу гэмтлийн нэр, мөн тусламж үйлчилгээ авсан эрүүл мэндийн байгууллагын нэрийг заавал бичих шаардлагатай

Холбоо барих

The Association for Overseas Technical Cooperation and Sustainable Partnerships (AOTS)
Corporate Liaison Group I, Corporate Liaison Department
30-1, Senju-Azuma 1-chome, Adachi-ku, Tokyo 120-8534, Japan TEL: +81-3-3888-8220
URL: www.aots.jp

FAX: +81-3-3888-8428